



Долоо хоног тутмын хэвлэл  
2016 оны 10 дугаар сарын 20  
№ 39 /948/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын  
хууль

2101

Монгол Улсын  
Засгийн газрын  
тогтоол

2103

Монгол Улсын  
Үндсэн хуулийн  
цэцийн дүгнэлт

2106

**Сонгуулийн тухай хуулийн  
зарим хэсэг хүчингүй болсонд  
тооцох тухай**

**Монгол Улсын 2016 оны төсөвт  
тодотгол хийж дуусах хүртэлх  
хугацаанд авах зарим арга  
хэмжээний тухай**

**Монгол Улсын шүүхийн тухай  
хуулийн 31 дүгээр зүйлийн  
31.6 дахь хэсэг Үндсэн хуулийн  
холбогдох заалтыг зөрчсөн  
эсэх маргааныг хянан  
шийдвэрлэсэн тухай**



**ГАРЧИГ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

- |      |  |      |
|------|--|------|
| 726. | Сонгуулийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай | 2101 |
|------|--|------|

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

- |      |   |                   |
|------|---|-------------------|
| 727. | Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 09 дүгээр дүгнэлтийн тухай | Дугаар 49<br>2102 |
| 728. | Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 10 дугаар дүгнэлтийн тухай | Дугаар 50<br>2102 |

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

- |      |   |                   |
|------|---|-------------------|
| 729. | Монгол Улсын 2016 оны төсөвт тодотгол хийж дуусах хүртэлх хугацаанд авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 38<br>2103 |
| 730. | Төсвийн зарим байгууллагыг өөрчлөн зохион байгуулах, татан буулгах тухай                            | Дугаар 55<br>2104 |

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

- |      |   |                   |
|------|---|-------------------|
| 731. | Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай | Дугаар 10<br>2106 |
|------|---|-------------------|

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 оны 10 дугаар сарын 07-ны өдөр	Улаанбаатар хот
-------------------------------------	-----------------

**СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСЭГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Сонгуулийн тухай хуулийн 160 дугаар зүйлийн 160.5 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2016 оны 10 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 10 дугаар  
сарын 06-ны өдөр

Дугаар 49

Улаанбаатар  
хот

### Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 09 дүгээр дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Сонгуулийн тухай хуулийн 160 дугаар зүйлийн 160.5 дахь хэсэгт “Нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтаас хасагдсаны улмаас дахин сонгууль явагдсан бол хасагдсан нэр дэвшигч хүн зургаан жилийн хугацаанд сонгуульд нэр дэвших болон төрийн албанд томилогдох, сонгогдох эрхээ алдах ба урьд явагдсан сонгуулийн сурталчилгааны болон зохион байгуулалтын бүх зардлыг нөхөн төлөх үүрэгтэй.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж заасныг зөрчсөн байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 09 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

2.Энэ тогтоолыг 2016 оны 10 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 10 дугаар  
сарын 06-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар  
хот

### Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 10 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэгт “... энэ хуулийн 31.5-д заасан тусгай саналын хамт ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.”, Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ.” гэж заасныг зөрчсөн байна.” гэсэн Үндсэн

хуулийн цэцийн 2016 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 10 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2.Энэ тогтоолыг 2016 оны 10 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2016 оны 08 дугаар  
сарын 17-ны өдөр

Дугаар 38

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын 2016 оны төсөвт тодотгол хийж дуусах хүртэлх хугацаанд авах зарим арга хэмжээний тухай**

Эдийн засаг, төсвийн хүндрэлтэй нөхцөл байдлаас үүдэлтэй төсвийн алдагдлыг бууруулах зорилгоор Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 34.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын 2016 оны нэгдсэн төсвийн эхний долоон сарын төсвийн гүйцэтгэлийг үндэслэн төсвийн жил дуусах хүртэлх хугацаанд дор дурдсан арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, бүх шатны төсвийн захирагч нарт даалгасугай:

1) төсвийн урсгал зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлж, бүх шатны төсвийн байгууллагын зарцуулагдаагүй цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, гадаад, дотоод томилолт, зочин, төлөөлөгч хүлээн авах зардал, тавилга, эд хогшил худалдан авах зардал, хангамж, бараа материалын болон сургалтын зардал, сурталчилгааны зардал, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад төсвөөс олгох татаас, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх зардал, бараа, үйлчилгээний бусад зардал, гэрээ байгуулаагүй, эсхүл байгуулсан боловч ажил нь эхлээгүй бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардлыг бууруулан зайлшгүй шаардлагатай зардлыг батлагдсан төсөвт багтаан санхүүжүүлэх;

2) 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс хойш бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг зарлахгүй, гэрээ байгуулахгүй байх;



3) 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс өмнө гэрээ байгуулсан боловч худалдан авалт нь эхлээгүй арга хэмжээний санхүүжилтийг зохих журмын дагуу зогсоох;

4) улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа болон Хөгжлийн банкны санхүүжилтээр төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шинээр зохион байгуулахгүй байх;

5) 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар гэрээ нь байгуулагдаагүй, ажлын гүйцэтгэл гараагүй, удаашралтай байгаа барилга байгууламжийн санхүүжилтийг зохих журмын хойшлуулах.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбатад даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН**

**ЕРӨНХИЙ САЙД**

**САНГИЙН САЙД**

**Ж.ЭРДЭНЭБАТ**

**Б.ЧОЙЖИЛСҮРЭН**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2016 оны 08 дугаар  
сарын 24-ний өдөр

Дугаар 55

Улаанбаатар  
хот

### **Төсвийн зарим байгууллагыг өөрчлөн зохион байгуулах, татан буулгах тухай**

Төсвийн тухай хуулийн 10.1.10, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9.5, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6<sup>1</sup>.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулах дараах байгууллагыг дор дурдсанаар өөрчлөн зохион байгуулсугай:

1.1. Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төвийг “Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв” болгож;

1.2. Ахмадын асрамж, хөгжлийн үндэсний төвийг “Ахмад настны үндэсний төв” болгож;

1.3. Хөдөлмөрийн эрүүл мэнд, судлалын төвийг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв” болгож;

1.4. Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээллийн төвийг “Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв” болгож;

1.5. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн “Өнөр бүл” төвийг “Өнөр бүл хүүхдийн төв” болгож;

1.6. Олон улсын хүүхдийн “Найрамдал” төвийг “Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор” болгож;

1.7. Хөдөлмөрийн яамны (хуучин нэрээр) харьяа “БНСУ дахь нэг цэгийн үйлчилгээний төв” болон Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны (хуучин нэрээр) харьяа “БНСУ дахь нийгмийн хамгааллын үйлчилгээний төв”-ийг нэгтгэн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа “БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” болгож.

2. “Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв”-ийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын харьяанд 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн ажиллуулсугай.

3. “Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, судалгаа, мэдээллийн үндэсний төв”-ийг татан буулгаж, зарим чиг үүргийг нь “Дадлагажигч ажилтан гадаадад илгээх төв” улсын төсөвт үйлдвэрийн газартай нэгтгэн “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт” болгож өөрчлөн зохион байгуулсугай.

4. Өөрчлөн зохион байгуулагдсан төсөвт байгууллагын дүрэм, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр, үйл ажиллагааны зардлыг 2016 оны төсвийн тодотголд тусган санхүүжүүлэхийг Сангийн сайд Б.Чойжилсүрэн нарт тус тус даалгасугай.

5. Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан төвийн үйл ажиллагааны зардлыг 2017 оны улсын төсвийн төсөлд тусгахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нарт даалгасугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Нэрэмжит болгох тухай” Засгийн газрын 2012 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 121 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлийн “Хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн өвчин



судлалын үндэсний” гэснийг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн” гэж өөрчилж, “Байгууллагын бүтцийг өөрчлөх тухай” Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 94 дүгээр тогтоол, “Төсвийн байгууллагуудад хийх бүтэц, зохион байгуулалтын зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2015 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 55 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт, “Бүгд Найрамдах Солонгос Улс дахь Нэг цэгийн үйлчилгээний төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 54 дүгээр тогтоол, “Улсын төсөвт үйлдвэрийн газар байгуулах тухай” Засгийн газрын 2016 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 299 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН**

**ЕРӨНХИЙ САЙД**

**Ж.ЭРДЭНЭБАТ**

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН**

**ХАМГААЛЛЫН САЙД**

**Н.НОМТОЙБАЯР**

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

2016 оны 09 дүгээр  
сарын 28-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 13.30 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Жанцан даргалж, гишүүдэд Ш.Цогтоо, Д.Наранчимэг/илтгэгч/, Д.Солонго, Д.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн О.Баясгалан, Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нар оролцлоо.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэгт “Хяналтын

шатны шүүх шийдвэрээ энэ хуулийн 31.5-д заасан тусгай саналын хамт ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.”, Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ.” гэсэн заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

***Нэг. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 14 дүгээр хорооны оршин суугч, иргэн О.Баясгалан Үндсэн хуулийн цэцэд хандаж ирүүлсэн мэдээлэлдээ:***

“Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.5 дахь хэсэгт “Шүүх хамтын зарчмаар хэрэг, маргааныг хянан хэлэлцэхдээ олонхийн саналаар шийдвэр гаргах ба цөөнх болсон шүүгч тусгай саналаа, хэрэв хэд хэдэн шүүгч тусгай саналтай бол тэдгээрийг нэгтгэж шүүхийн шийдвэрт хавсаргана.” гэсэн байна. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн зорилт нь шүүхийн тогтолцоо, зохион байгуулалт, бүрэн эрх, үйл ажиллагааны эрх зүйн үндэс, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх баталгааг тогтооходой холбогдсон харилцааг зохицуулах ёстой. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх баталгааг тогтоох харилцааны нэг гол зүйл нь шүүгч өөрийн үүргийг гүйцэтгэсний төлөө олон нийт болон хэргийн оролцогчоос үзүүлэх зүй бус нөлөөллөөс хамгаалагдах ёстой. Гэтэл хэрэг, маргааныг хамтын зарчмаар шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг гаргасан шүүгч би тусгай саналтай байна гээд түүнийг олон нийтэд ил тод болгоод байвал шүүхэд хэн итгэх вэ. Өөрөөр хэлбэл шүүхийн шийдвэр таалагдаагүй тал шүүгчийг ялгаварлан үзэх улмаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэр төрд нь халдах нөхцөлийг бүрдүүлэх бөгөөд шүүгч болон шүүхийн нэр хүндийг унагах нөхцөлийг бүрдүүлэх юм.

Мөн энэ хуулийн 31 дүгээр зүйлийн 31.5 дахь хэсгийн “Шүүх хамтын зарчмаар хэрэг, маргааныг хянан хэлэлцэхдээ олонхийн саналаар шийдвэр гаргах ба цөөнх болсон шүүгч тусгай саналаа, хэрэв хэд хэдэн шүүгч тусгай саналтай бол тэдгээрийг нэгтгэж шүүхийн шийдвэрт хавсаргана.” гэсэн заалтад буй хэд хэдэн шүүгч гэсэн ойлголт нь зөвхөн хяналтын шатны шүүхэд хамааралтай байна.

Хяналтын шатны 5 шүүгчийн 2 шүүгч нь тусгай саналаа ил тавьсан үед олон нийт шүүгчдийг өөрийн үзэмжээр дүгнэх бөгөөд шүүгч нарыг





харьцуулах, шүүхэд эргэлзэх байдлыг бий болгох сөрөг үр дагавартай гэж үзэж байна. Хамтын зарчмаар хэрэг, маргааныг шийдвэрлэх нь түүний үр дагаврыг хамт хариуцах, зөвлөлдөх тасалгааны нууцыг задлахгүй байх тухай ойлголт юм. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 320 дугаар зүйлийн 320.1.4 дэх заалтын “зөвлөлдөх тасалгаанд болсон шүүгчдийн зөвлөгөөний нууцыг задруулсан,” гэсэн нь ноцтой үйлдэл бөгөөд заавал хүчингүй болгох зохицуулалт үйлчилж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэгт “Хяналтын шатны шүүх шийдвэрээ энэ хуулийн 31.5-д заасан тусгай саналын хамт ...” гэж заасан нь Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ.” гэсэн заалтыг зөрсөн эсэх талаар хянан хэлэлцэж шийдвэр гаргаж өгнө үү.” гэсэн байна.

***Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:***

“1. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ.” гэдэгт шүүх тухайн асуудлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор хэлэлцэж, олонхийн саналаар хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий, шударга шийдвэр гаргахыг ойлгодог бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн уг заалтыг баталгаажуулж Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.5 дахь хэсэгт “Шүүх хамтын зарчмаар хэрэг, маргааныг хянан хэлэлцэхдээ олонхийн саналаар шийдвэр гаргах ба цөөнх болсон шүүгч тусгай саналаа, хэрэв хэд хэдэн шүүгч тусгай саналтай бол тэдгээрийг нэгтгэж шүүхийн шийдвэрт хавсаргана.” гэж тусгасан. Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн дээр дурдсан заалтын дагуу Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудад анхан шатны журмаар шүүгч дангаар хянан шийдвэрлэхээс бусад хэрэг, маргааныг 3 шүүгчийн бүрэлдэхүүнээр, давж заалдах журмаар хэрэг, маргааныг 3 шүүгчийн бүрэлдэхүүнээр, харин хяналтын журмаар хэрэг, маргааныг 5 шүүгчийн бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэхээр заасан.

2. Шүүхэд урьдаас хөдөлбөргүй үнэн гэж тогтоогдсон ямар ч нотлох баримт байж болохгүй бөгөөд хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд шүүгч бүр хууль болон эрх зүйн ухамсрыг удирдлага болгож, нотлох баримтыг тал бүрээс нь нягт нямбай, бүрэн гүйцэд, бодит байдлаар нь хянаж, харьцуулан үзсэний үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлж, зөвлөлдөн санал нийлсний үндсэн дээр шийдвэр гаргадаг ба бусад шүүгчтэй санал нийлээгүй бол тусгай саналаа бичгээр гаргадаг. Энэхүү шүүхийн шийдвэрийг цахим хуудсанд байршуулж, хэвлэн нийтэлж байгаа нь шүүх хэрэг, маргааныг хянан хэлэлцэж шийдвэр гаргасны дараа хийгдэж байгаа ажиллагаа бөгөөд хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд огт хамааралгүй, шүүхийн захиргааны байгууллагын зүгээс явуулж байгаа олон нийтэд шүүхийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгахад чиглэсэн ажлын нэг хэлбэр юм.

3. Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд шүүгч тусгай санал гаргаснаар хэн нэгэн этгээд шүүх, шүүгчийн нэр төрд халдана гэх асуудлыг хуулиар хамгаалсан бөгөөд энэ талаар Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлд “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана. Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй.” гэж шүүгчийн хараат бус байдлыг баталгаажуулж өгсөн байдаг.

4. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн ...” гэж заасан ба хяналтын шатны шүүхийн эрх хэмжээг хэрэгжүүлдэг. Мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. ...” гэж заасанчлан шүүхийн шийдвэр, үүний дотор Улсын дээд шүүхийн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэсэн шийдвэр, шүүгчийн тусгай саналыг цахим хуудсанд байршуулснаар хуулийн чиглэлээр суралцаж байгаа оюутан, эрдэм шинжилгээний ажилтнууд төдийгүй хууль тогтоогч баталсан хууль нь амьдралд хэрхэн хэрэгжиж байгаа талаар бодитойгоор мэдэх, иргэд шүүх, шүүгч хэрхэн ажиллаж байгаад үнэлэлт, дүгнэлт өгч, харин ч шүүхэд үл итгэх эргэлзээг арилгах боломжтой юм.

5. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин дөрөвдүгээр зүйлд “Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүх хэргийг ил таслан



шийдвэрлэнэ.”; Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалтад “... Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;” гэж заасан бөгөөд төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, шүүгчийн тусгай саналыг шүүхийн цахим хуудсанд байрлуулж, хэвлэн нийтлэх нь хэн нэгний эрх, эрх чөлөөнд халдаж байгаа үйлдэл бус, харин ч Үндсэн хуулиар баталгаажсан төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах иргэний үндсэн эрхийг эдлүүлэх боломжийг хангаж байгаа үйлдэл юм.

Иймд иргэн О.Баясгалангийн мэдээлэлдээ дурдсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэгт “Хяналтын шатны шүүх шийдвэрээ энэ хуулийн 31.5-д заасан тусгай саналын хамт ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ.” гэсэн заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.” гэсэн байна.

**Гурав.** Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны явцад мэдээлэл гаргагч Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэгт “Хяналтын шатны шүүх шийдвэрээ энэ хуулийн 31.5-д заасан тусгай саналын хамт ...” гэж заасан нь Үндсэн хуулиар баталгаажуулсан шүүгчийн хараат бус байдлын зарчмыг давхар зөрчиж байгаа талаар үндэслэлээ тайлбарлан илэрхийлэв.

#### **ҮНДЭСЛЭЛ:**

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 03 дугаар дүгнэлт, 2016 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... тусгай санал гаргасан гишүүний саналыг Цэцийн шийдвэрт хавсаргана.” гэсэн нэмэлт оруулсан нь тусгай саналтай гишүүний саналыг өөрийн хүсэлтийг нь үл харгалзан заавал нийтэлж байх үүрэгжүүлсэн шинж бүхий зохицуулалт болсон ба энэ нь Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан Цэцийн гишүүний хараат бус байдлын баталгааг алдагдуулсан гэж үзэхээр байна гэсэн үндэслэлээр дээрх заалтыг хүчингүй болгосон байна.

2. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.5, 31.6 дахь хэсэгт хяналтын шатны шүүх хэрэг, маргааныг хяналтын журмаар, хамтын зарчмаар хянан хэлэлцэхдээ цөөнх болсон шүүгч бүр өөрийн саналаа тусгай санал болгон шүүхийн шийдвэрт заавал хавсаргах ба шүүхийн шийдвэрийг тусгай саналын хамт өөрийн цахим хуудсанд байрлуулж, хэвлэн нийтлэхээр зохицуулсан байна. Энэ нь Үндсэн хуулийн цэцийн дээрх шийдвэрт дурдсан хуулийн заалттай адил агуулгатай байх тул шүүгчийн хараат бус байдлын баталгааг алдагдуулсан гэж үзэхээр байна. Түүнчлэн шүүгчийн тусгай саналыг заавал нийтлэхээр хуульчилсан нь шүүхийн зөвлөлдөх тасалгааны нууцыг задруулах нөхцөлийг бүрдүүлж байна.

3. Хяналтын шатны шүүх хэрэг, маргааныг хяналтын журмаар, хамтын зарчмаар хянан хэлэлцэхдээ шүүгч бүр нотлох баримтыг өөрийн итгэл үнэмшлээр үнэлэн саналаа чөлөөтэй илэрхийлж олонхийн саналаар шийдвэрлэдэг. Олонхтой санал нийлээгүй шүүгч тусгай санал гаргах эрхтэй боловч түүний саналыг заавал нийтлэхээр үүрэгжүүлэн хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ.” гэсэн заалтыг зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

#### **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1. Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэгт “... энэ хуулийн 31.5-д заасан тусгай саналын хамт...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.”, Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6



дахь хэсгийн “... энэ хуулийн 31.5-д заасан тусгай саналын хамт ...” гэсэн заалтын үйлчлэлийг 2016 оны 9 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын дараагийн чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ**  
**ГИШҮҮД**

**Н.ЖАНЦАН**  
**Ш.ЦОГТОО**  
**Д.НАРАНЧИМЭГ**  
**Д.СОЛОНГО**  
**Д.ГАНЗОРИГ**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [tugin\\_medecelel@parliament.mn](mailto:tugin_medecelel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 0.75

**Индекс: 14003**